

УЛС ТӨРД ИНТЕРНЕТИЙН СҮЛЖЭЭГ АШИГЛАХ НЬ

INTERNET USAGE IN POLITICS

**Д.БАТЦЭЦЭГ**

ХСИС-ийн Эрх зүй, Нийгмийн ухааны сургуулийн Нийгмийн ухааны тэнхимийн ахлах багш, цагдаагийн ахмад

BATTSETSEG D.

Senior lecturer of faculty of social sciences, Institute of Law and Social sciences, Law enforcement university, Police captain

Товч агуулга: Шилжилтийн үеийн өнөөгийн нийгэмд иргэдийн улс төрийн оролцоо маш ихээр сулардаг. Ийм нөхцөлд иргэдийн энэхүү идэвхгүй байдлыг интернет сүлжээний тусламжтайгаар өөрчлөх боломжтойг олон улсын туршлага дээр тулгуурлан тайлбарлахыг оролдлоо.

Abstract: : Today, in a transitional period the political participation of citizens in society weakens dramatically. Based on international experience, our report is focused on the reformation of how to change citizens' inactivity with the help of the internet usage.

Мэдээлэл харилцааны асуудал нь улс төрийн амьдралд чухал байр суурь эзэлдэг бөгөөд сонин хэвлэл, зурагт радио гэх мэт мэдээллийн хэрэгслээр улс төрийн өөрчлөлтийг мэдээлсээр ирсэн билээ. Өнөөдрийн нийгэмд интернет нь нийгмийн амьдралын зарим асуудлыг шийдэж чадахгүй байгаа ч бидний амьдралыг эрс өөрчилж байгааг дурдах хэрэгтэй. Интернетийн сүлжээ нь хэн, хэзээ ч төсөөлж байгаагүйгээр хурдацтай хөгжиж байгаа бөгөөд техникийн ололт амжилт гэхээс илүүтэйгээр хүн төрөлхтний бүхий л амьдралын туршид нөлөөлөх нэгэн том хүчин зүйл болоод байна.

Интернет нь нийгмийн болон бусад шинжлэх ухааны салбарын хэтийн төлөв ирээдүйг нь төлөвлөхөд ихээхэн нөлөөлж байна. Үүний зэрэгцээ Интернет нь улс төрд чухал байр суурь эзэлж байгаа гэдгийг харгалзан үзэх хэрэгтэй. Интернет нь 2 үе шаттайгаар улс төрийн амьдралд нөлөөлж байна.

Одоогийн байдлаар интернетийг улс төрийн мэдээлэл дамжуулах зорилгоор ашиглаж байгаа ба гол зорилго нь сүлжээнд улс төрийн мэдээллийг байрлуулахад оршино. Үүнд голдуу улс төрийн намууд болон олон нийтийн байгууллагууд, биеэ даасан улс төрчдийн веб хуудаснууд болон сонин сэтгүүл, судалгааны байгууллагуудын сайтууд ордог.

Өнөөдөр интернет ашиглахгүйгээр засгийн эрхийн төлөөх тэмцэлд ялна гэдэг нь харьцангуйгаар боломжгүй болоод байгаа бөгөөд энэ явц нь ирээдүйд улам л их болж, улс төрийн нам, хөдөлгөөнүүдийн сайтууд улам нэмэгдэж, интернэтийн мэдээллийн үүрэг өссөөр байх болно. Иймээс интернэт нь хэзээ нэгэн

цагт мэдээллийн гол эх сурвалж болно гэдгийг харуулж байна.

Компьютерийн технологи нь олон талын харилцааны боломжийг нээдэг. Сүлжээнд нэвтрэгч хэн бүхэн мэдээлэл авахын зэрэгцээ мөн мэдээллийг цацаж байдаг.

Интернэт нь сонгуулийн кампанит ажлын үеэр социологийн судалгааны хүрээг өргөжүүлж, үйл ажиллагааг чанаржуулдаг. Энд зөвхөн нэр дэвшигчдийн рэйтингийг өсгөх асуудлын тухай, социологийн асуулгын тухай л ярьж байгаа гэсэн үг биш юм.

Хэрэглэгчид нь интернэтэд нэвтрэн орсноор нэр дэвшигчдийн тухай видео файлаас бүрэн бүтэн мэдээллийг олж авдаг. Үүний зэрэгцээ интернэтэд улс төрийн үйл ажиллагааны сурталчилгааг голлон төвлөрүүлсэн байдаг. Зурагтаар гарч байгаа реклам нь хэдхэн секунд, хэвлэлийн хуудаснаа хэдхэн өдөр байдаг бол интернэтийн сүлжээн дэх видео файлууд нь сар, жилүүдээр ч байрладгаараа маш их давуу талыг олгож байдаг.

Интернэт нь засгийн эрх баригч болон иргэд хоорондын нийгэм улс төрийн маргаан, мэтгэлцээний байнгын талбар болж байдаг. Өөрөөр хэлбэл, Засгийн эрх баригчдыг жирийн иргэдтэй ойртох бодит боломж бий болж байна гэсэн үг юм. Иргэд болон төр засгийн хоорондох шууд холбоог энгийн болгосноор улс төрд оролцохгүй байх гэсэн хандлагыг багасгаж, үүний дотор ялангуяа залуучуудыг улс төрд татан оролцуулах тал дээр их нөлөөлж байна.¹ Интернэт нь бодит амьдрал дээр нэг үзэл бодолтой хувь хүмүүсийн хоорондох улс төрийн шууд харилцаа болон тэдний хооронд холбоо тогтооход туслалцаа үзүүлдэг.² Тэдгээр нь газарзүйн орчны нөхцөл байдал, хол ойроос үл хамааран бие биендээ туслан мэдээллээ солилцож, цаашдын үйл ажиллагааныхаа тактикийг боловсруулан ажилладаг.

Интернет нь дэлхийн улс орны ард иргэдийн даяарчлалыг бий болгоход, мөн тэднийг нэгдэж нягтрахад тус дөхөм болдог. Дэлхий дээр өнөөдөр 30 гаруй мянган төрийн бус олон нийтийн байгууллагууд байдаг гэсэн тоо баримт байдаг бөгөөд энэ нь интернетийн тусламжтайгаар улам бүр өсөх хандлагатай байна.

1995 онд Эдийн засгийн хамтын ажиллагаа болон хөгжлийн асуудал хариуцсан байгууллага нь "Олон улсын эдийн засгийн асуудлыг тогтмолжуулах" гэрээнд гарын үсэг зурах хэлэлцээрээ эхлэх үед үүнийг эсэргүүцэн холбоо байгуулагджээ. Дэлхийн 70 орны тэс өөр зорилго бүхий "Amnesty International" болон "Oxfam" аас авахуулаад "Sierra Club" хүртэл багтсан 600 гаруй байгууллагууд уг гэрээг эсэргүүцэж байгаагаа дуу нэгтэйгээр илэрхийлж, 1998 онд интернетээр уг зорилгоосоо татгалзахыг засгийн газраас шаардсан байна. Мөн 1300 гаруй төрийн бус байгууллагууд "Цэргийн мин буюу дэлбэрэх бөмбөгийг эсэргүүцсэн акт"-ыг дэмжсэн хөдөлгөөн өрнүүлсэн бөгөөд тэдний тэмцлийн үр дүнд уг дэлбэрэх бөмбөгийг хориглох тухай гэрээ нь хүчин төгөлдөр болж, энэ ажиллагаа нь дэлхийн хэмжээний Нобелийн шагнал авсан дуулиант хэрэг болж байжээ.

Интернетийг сүүлийн үед нь олон улсын хэмжээнд чухал чухал бага хурлуудыг явуулахтай холбогдсон эсэргүүцсэн мэдээлэл цацахад ихээхэн ашиглаж байна. Үүний нэг тод жишээ бол Сиэтлэд болсон Дэлхийн худалдааны байгууллагуудын бага хурал, Вашингтон болон Прагт болсон олон улсын валютын

¹ Херманн М. К. Политическая коммуникация: воздействие средств массовой информации на общество в современных государствах. // www.NetHistory.Ru/biblio/1043179735.html

² Рот К-Х. Глобализация. Новые классовые отношения и перспективы левых. www.avtonom.org/lib/index.html

фонд болон Дэлхийн банкны бага хурлууд зэрэг юм.

Ер нь нийгэм, эдийн засаг, улс төрийн эсрэг эсэргүүцэл гаргах нь нийгэмд зайлшгүй байдаг үзэгдлийн нэг юм. Үүнд л Интернет нь олон улсын болон даярчлалын хүчин зүйлийг агуулж байдаг маш хүчирхэг зэмсэг болдгоороо онцлогтой. Уг хүчин зүйл нь аливаа орны засаг төрд шахалт үзүүлж тэдгээрийн зүй бус ажиллагааг зогсоох эсвэл улс төрийн үйл ажиллагаагаа зөв явуулахад нь тус нэмэр болох тал дээр гол анхаарлаа төвлөрүүлж байдаг.

Интернетэд шинэ улс төрийн намыг үүсгэн бий болгох, нэг үзэл бодол, нэг зорилго бүхий улс төрийн ажиллагаанд нэгдэхэд зориулагдсан тусгай сайтууд байдаг. Жишээ нь Украинд улс төрийн нэг шинэ намыг³ интернетийн тусламжтайгаар байгуулсан байна.

Өнөөдөр ардчилсан сонгуулийн тогтолцооны хямралын талаар, залуу үеийн сонгуульд оролцох тал дээр хайнга хандаж байгаа талаар их ярьцгааж байна. Энэ асуудлыг шинэ технологийн хүчээр шийдэж чадна гэж үзэж байна. Ирээдүйд сонгуулийг сонгогчдийн болон нэр дэвшигчдийн аль алиныхыг нь таашаалд нийцүүлсэн маягаар явуулах, сонгуулийн явцыг хурдасгах дээр анхаарах юм бол үр дүн нь яв цав байх юм. Гол нь Интернетээр дамжуулж саналаа өгөх технологийг л хөгжүүлэх хэрэгтэй юм. Анхны туршилтыг /Federal Voting Assistance Program/ 2000 оны 11 сард хэрэгжүүлсэн бөгөөд үүнд гадаадад амьдардаг 84 иргэн саналаа өгсөн байх жишээтэй. 2003 онд Швейцарын нэгэн орон нутгийн сонгууль нь онлайнаар явагджээ. Германд интернетээр сонгууль явуулна гэдгээ 2006 онд зарлаж байжээ.

Сүүлийн үед электрон засаг /e-Government/ гэсэн технологи буюу төрийн удирдлагын нэгэн шинэ загвар гараад байгаа бөгөөд Интернетийн тусламжтайгаар төр болон нийгэм харилцан үйл ажиллагаагаа явуулж байна. Гол зорилго нь иргэдэд засгийн газраас үзүүлэх үйлчилгээг сайжруулах, улс орныг удирдах явцад сонгогчдыг оролцуулахад оршиж байгаа юм. Электрон засгийн газар нь уламжлал ёсоор 3 төрөлд хуваагдана.

1. Засгийн газар — иргэд /G2C/: Интернетийн тусламжаар мэдээлэл олж авах, санал асуулганд оролцох;

2. Засгийн газар — хувийн бизнес /G2B/: бараа материалаар хангах болон үйлчилгээ;

3. Засгийн газар - Засгийн газар /G2G/: мэдээллийг хамтранашиглах төрийн байгууллагын дотоод хамтын ажиллагааг явуулдаг байна.

GOL төсөл нь 1998 оныг дуустал хэрэглэгдэж, захиргааны болон төрийн эрх барих байгууллага нь иргэдтэйгээ орчин үеийн ямар харилцааны арга хэрэгслийн тусламжтайгаар холбоотой байх вэ гэсэн туршлага хураах зорилготойгоор байгуулагдсан. Уг төсөлд дэлхийн 20 гаруй орны байгууллагууд болон нэр хүнд бүхий олон улсын байгууллагууд оролцжээ.

2000 оны 9 сард АНУ-д "FirstGov"⁴ буюу "АНУ-ын засгийн газар руу хийх эхний алхам" нэртэй төсөлт ажлаа эхэлсэн. Ийм маягийн төслүүд дэлхийн бусад орнуудад хэрэгжсээр байна. Өнөөдөр дэлхийн зарим орнуудад машинаа бүртгүүлэх, жолооны эрхээ сунгуулах, урт дараалалд зогсож татвараа төлөх гэсэн асуудлуудыг интернетээр шийдэж байна. Интернетийн технологийн хөгжлийг дэмжиж чадвал:

³ www.vpu.org.ua

⁴ <http://www.firstgov.gov>

о Нийгэм дэх хүнд суртал болон авилга багасна.

о Засгийн газраас гарах бүх үйлчилгээ нь онлайн системд орж засаг захиргааны үйл ажиллагаа нь электрон хэлбэрээр явагдаж, цаасны ажил багасна.

Интернетийг улс төр, засгийн газрын үйл ажиллагаанд хэрэглэж чадсанаар засгийн газарт үзүүлэх давуу тал :

- Олон нийт нь улс төрийн төсөл санаачлагад бодитойгоор оролцох боломжтой болно. Олон нийтийн санал бодлын тухай бодит мэдээллийг маш түргэн шуурхай бөгөөд элдэв зардалгүйгээр олж авах боломжтой.

- Засгийн газрын төлөвлөгөөг хурдан шуурхай хэрэгжүүлэх боломж. Орон нутгийн эрх барих байгууллагуудтай үр дүнтэй холбоо тогтоох.

- Ард түмэн болон засгийн газар хоорондын идэвхгүй харилцааны асуудлыг шийдэх

- Ардчилсан нийгмийн гол асуудал болсон засгийн газрын төлөвлөгөөг ард түмэнд танилцуулах

Интернетийг улс төр, засгийн газрын үйл ажиллагаанд хэрэглэж чадсанаар олон нийтэд үзүүлэх давуу тал:

- Хүмүүсийн саналыг сонсоно

- Хэрэгжүүлж байгаа төслүүд нь зөвхөн засгийн газар дээр бус тодорхой хүмүүсийн санал дээр тулгуурласан байна.

- Төслийг хэрэгжүүлэхийг хурдасгах

- Ил тод байсны үндсэн дээр төсөл хэрэгжих хугацаа болон зардлыг багасгана

- Засгийн газартай харилцах харьцаа нь энгийн болох учраас ард түмний амьдралд хөнгөн болно

- Өргөдөл гомдлыг хянан үзэх ажиллагаа нь түргэн шуурхай болоод шударга болно

- Мэдээллийг олж авснаар ард түмэн өөрт байгаа боломжийг ашиглаж чадна

- Ил тод байснаар ард түмэн засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих боломжтой болох бөгөөд авилгыг бууруулах хандлагатай

- Хилийн чандад байгаа хүмүүс өөрийн эх оронд болж буй үйл хэрэгт оролцох боломж бий болно.

- Үүгээр өөрийн яс үндсийн хамаарлыг улам сайн мэдрэх

- Маш олон төлбөргүй сургалтын хөтөлбөрүүдтэй танилцаж болно

2010 оны сүүлээр америкийн төрийн удирдлагын нийгэмлэг нь (APSA) төрийн эдийн засаг болон удирдлагын хэлтэстэй (UNDPEPA)